



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 8/278

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3 дахь заалт, Иргэний нисэхийн дүрэм-71 “Агаарын зайг тогтоох болон ангилах”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Иргэний нисэхэд ашиглах агаарын зайг тогтоох, ангилах технологи үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Иргэний нисэхэд ашиглах агаарын зайг тогтоох, ангилах технологи үйл ажиллагааны журам”-ыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс мөрдөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийн газар (Ч.Одгэрэл)-т даалгасугай.

3. “Иргэний нисэхэд ашиглах агаарын зайг тогтоох, ангилах технологи үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Мөнхнасан)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ТӨРБАЯР

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн
А/278... дугаар тушаалын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХЭД АШИГЛАХ АГААРЫН ЗАЙГ ТОГТООХ, АНГИЛАХ ТЕХНОЛОГИ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага (цаашид ОУИНБ гэх)-ын стандарт шаардлага, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журам болон Иргэний нисэхийн дүрэм-71 “Агаарын зайг тогтоох болон ангилах”-ийн (цаашид ИНД-71 гэх) шаардлагыг бүрэн хангахуйц иргэний нисэхэд ашиглах агаарын зайг тогтоох, ангилахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.1.1. Энэхүү журмын 1.1-д заасан “агаарын зайг тогтоох” гэсэн ойлголтод агаарын зайг шинээр тогтоох эсхүл тогтоогдсон агаарын зайн ангилал, зориулалт, бүтэц, хил хязгаарыг өөрчлөх, хүчингүй болгох үйл ажиллагаа багтана.

1.1.2. Энэхүү журмын 1.1-д заасан “агаарын зайг ангилах” гэж ИНД-71-ийн С бүлэгт заасны дагуу ангилахыг хэлнэ.

1.2. Иргэний нисэхэд ашиглах агаарын зайн аюулгүй байдлыг хангах, агаарын зайн зохион байгуулалтыг сайжруулах, багтаамж, үр ашгийг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор агаарын зайг тогтоож, ангилах бөгөөд агаарын зайг аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй ашиглах зарчмыг баримтална.

1.3. Агаарын зайг тогтоох, ангилах үйл ажиллагаа нь ОУИНБ-ын хүрээлэн буй орчныг хамгаалах бодлого болон агаарын тээвэрлэгчид, агаарын зайн оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Хоёр. Удирдлагын оролцоо, үүрэг

2.1. Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх) нь агаарын зайг тогтоох, ангилах үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллага, хуулийн этгээдтэй зөвшилцөх, санал солилцож хамтран ажиллана.

2.2. ИНЕГ-ын агаарын зайн бодлогын хэрэгжилт хариуцсан нэгжийн дарга агаарын зайг тогтоох, ангилах үйл ажиллагааг төлөвлөх, удирдлагаар хангана.

Гурав. Үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. ИНЕГ-ын мэдээлэл технологи хариуцсан нэгж эсхүл мэргэжилтэн энэхүү журмын Хавсралт 4-т заасан “Агаарын зайг тогтоох, ангилах саналын маягт”-ыг ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулна.

3.2. ИНЕГ нь агаарын навигацийн үйлчилгээний байгууллага болон агаарын зайн хэрэглэгчээс “Агаарын зайг тогтоох, ангилах саналын маягт”-ын дагуу ирүүлсэн саналыг хүлээн авч, судална.

3.2.1. Энэхүү журмын 3.2-т заасан “агаарын зайн хэрэглэгч” гэж Монгол Улсын агаарын зайд иргэний болон улсын нислэг үйлдэж буй агаарын тээвэрлэгч, иргэний болон улсын нисэхийн байгууллагыг хэлнэ.

3.3. ИНЕГ-ын агаарын зайн бодлогын хэрэгжилт хариуцсан нэгж нь дээрх саналыг судалсны үндсэн дээр анхан шатны шийдвэрийг санал гаргагчид хүргүүлнэ.

3.3.1. Энэхүү журмын 3.3-т заасан “анхан шатны шийдвэр” гэж агаарын зайг тогтоох, өөрчлөх саналыг хүлээн авч, судлан, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг урьдчилсан байдлаар мэдэгдэхийг хэлнэ.

3.4. Дарга шаардлагатай тохиолдолд иргэний нисэхэд ашиглах агаарын зайг тогтоох, ангилах үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэргэжлийн багаас бүрдсэн ажлын хэсэг байгуулна.

3.5. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд иргэний нисэхийн хяналтын байцаагч (агаарын навигацийн үйлчилгээ хариуцсан), иргэний нисэхийн хяналтын байцаагч (агаарын зайн зохион байгуулалтын хяналт, зохицуулалт хариуцсан), иргэний нисэхийн хяналтын байцаагч (нислэгийн урсгал төлөвлөлт, зөвшөөрөл хариуцсан), нислэгийн хөдөлгөөний менежментийн мэргэжилтэн, нисгэгч, нислэгийн хөдөлгөөний удирдагч, нислэгийн журам зохиогч, холбоо, навигаци, ажиглалтын инженер, нислэгийн зургийн инженер, нисэхийн мэдээллийн мэргэжилтэн, газар зүйн мэдээллийн инженер, нисэх буудлын төлөөлөл, улсын нисэхийн төлөөллийг харилцан зөвшилцсөний дагуу оролцуулна.

3.6. Ажлын хэсэг нь эрсдэлийн үнэлгээ, нөлөөллийн шинжилгээ хийх чадамж бүхий бүрэлдэхүүнтэй байна.

Дөрөв. Агаарын зайг тогтоох, ангилах ажиллагаа

4.1. Энэхүү журмын 3.4-т заасан ажлын хэсэг нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

4.1.1. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй агаарын зай тогтоосон, ангилсан шийдвэртэй танилцах;

4.1.2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй агаарын зайн зохион байгуулалтад дүн шинжилгээ хийх;

4.1.3. Өөрчлөлт оруулах шаардлагатай агаарын зайн мэдээлэл болон нислэгийн журам (SID, STAR), сектор зохион байгуулалт, холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжийн хүчин чадал, хамрах хүрээнд дүн шинжилгээ хийх;

4.1.4. Агаарын зайн өөрчлөлтийн урьдчилсан төслийг боловсруулах;

4.1.4.1. Энэхүү журмын 4.1.4-т заасан “өөрчлөлтийн урьдчилсан төсөл” гэж агаарын зайг тогтоох, ангилах зорилгоор тухайн өөрчлөлтийг урьдчилсан байдлаар зурган хэлбэрээр оруулж, мэдээлэл бэлтгэхийг хэлнэ.

4.1.5. Аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх;

- 4.1.6. Шаардлагатай тохиолдолд нислэгийн хөдөлгөөний удирдлага (цаашид НХУ гэх)-ын дадлагажуурын байранд туршилт явуулах;
- 4.1.7. Эрсдэлийн үнэлгээ, НХУ-ын туршилтын үр дүнг харгалзан урьдчилсан төсөлд холбогдох өөрчлөлтийг оруулах;
- 4.1.8. Агаарын зайн өөрчлөлтийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхлэх огноог тодорхойлох;
- 4.1.9. Агаарын зайн өөрчлөлтийн талаар агаарын зайн оролцогч талуудыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулах, хэлэлцүүлгийн тэмдэглэл үйлдэх;
- 4.1.10. Хэлэлцүүлгийн үр дүнг харгалзан шаардлагатай тохиолдолд төсөлд өөрчлөлт оруулах;
- 4.1.11. ОУИНБ-ын iCARD системээр дамжуулан тодорхой цэгийн 5 үсгийн код авах;
- 4.1.11.1. Энэхүү журмын 4.1.11-т заасан “тодорхой цэг” гэсэн ойлголтод орох, гарах цэг, заавал илтгэх цэг, хүсэлтээр илтгэх цэг, замын цэг, ил харааны илтгэх цэгийг тус тус ойлгоно.
- 4.1.12. Нислэгийн хөдөлгөөний удирдлага хариуцсан нэгжээс шинээр тогтоож буй тодорхой цэгийн нэрний талаар санал авах;
- 4.1.13. Нислэгийн хөдөлгөөний удирдлага хариуцсан нэгжээс ирүүлсэн саналаас шалтгаалан шаардлагатай тохиолдолд ОУИНБ-аас тодорхой цэгийн 5 үсгийн кодыг өөрчлөн авах;
- 4.1.14. Агаарын зайн өөрчлөлтийг батлах тухай Зам, тээврийн сайдын тушаалын төсөл боловсруулах;
- 4.1.15. Зам, тээврийн сайдын тушаалын төсөл боловсруулахдаа тухайн шийдвэрээр өмнөх хүчин төгөлдөр шийдвэрийг хүчингүй болсонд тооцож байгаа, эсхүл түүнд өөрчлөлт оруулж байгаа бол энэ тухай заалтыг тусгасан байх, тухайн шийдвэр хэрэгжиж эхлэх огноог нисэхийн мэдээллийн AIRAC тогтолцооны тооцоот хугацаатай уялдуулан тогтоох;
- 4.1.16. Зам, тээврийн сайдын тушаалын төслийн хавсралтаар батлагдах агаарын замын мэдээллийг энэхүү журмын Хавсралт 1-д заасан “Агаарын замын мэдээллийн загвар”-ын дагуу боловсруулах;
- 4.1.17. Зам, тээврийн сайдын тушаалын төслийн хавсралтаар батлагдах агаарын зайн мэдээллийг энэхүү журмын Хавсралт 2-д заасан “Агаарын зайн мэдээллийн загвар”-ын дагуу боловсруулах;
- 4.1.18. Захиргааны ерөнхий хуулийн дагуу нөлөөллийн шинжилгээ хийх, нөлөөллийн шинжилгээний танилцуулга бэлтгэх;
- 4.1.19. Зам, тээврийн сайдын тушаалын төслийг ИНЕГ-ын цахим хуудаст 30-аас доошгүй хоног байршуулан, олон нийтээс нээлттэй санал авах;
- 4.1.20. Ажлын хэсгийн тайлан бэлтгэх;
- 4.1.21. Ажлын хэсгийн тайлан, холбогдох шийдвэрийн төслийг Даргад танилцуулах.

4.2. Агаарын зайн бодлогын хэрэгжилт хариуцсан нэгж нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

4.2.1. Агаарын зайг тогтоох, ангилах тухай Зам, тээврийн сайдын тушаалын төслийг хавсралтын хамт иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, батлуулах ажлыг зохион байгуулах;

4.2.2. Зам, тээврийн сайдын гаргасан тушаалыг хэрэгжүүлэх тухай ИНЕГ-ын даргын тушаалын төслийг бэлтгэн, батлуулах ажлыг зохион байгуулах;

4.2.3. Тогтоосон, ангилсан агаарын зайг олон улсад зарлан мэдээлэх, хэрэгжилтэд хяналт, зохицуулалт хийх.

Тав. Агаарын зайг тогтоох, ангилах аргачлал

5.1. Энэхүү журмын 4.1, 4.2-т заасан ажлыг хийж гүйцэтгэхдээ тус журмын Хавсралт 3-т заасан "Агаарын зайг тогтоох, ангилах ажиллагаанд шаардлагатай тооцоот хугацаа"-аас хэтрүүлэхгүй байх зарчмыг баримтална.

5.2. Тухайн өөрчлөлтийн цар хүрээнээс шалтгаалан дээрх заасан хугацаанаас бага хугацаанд гүйцэтгэж болно.

5.3. Агаарын зайд өөрчлөлт орох тохиолдолд:

5.3.1. Агаарын зайг нэрлэх;

5.3.2. Агаарын зайн ангилал, зориулалтыг тодорхойлох;

5.3.3. Агаарын зайд хамаарах холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжийн бүрхэлтийн судалгаа хийх;

5.3.4. Агаарын зайн ашиглалтын судалгаа хийх;

5.3.5. Агаарын зайн хэвтээ хязгаарын цэгүүдийн уртраг болон өргөргийг тодорхойлох (WGS-84 газар зүйн солбицлын систем ашиглана);

5.3.6. Агаарын зайн дээд болон доод хязгаарыг (шилжих өндрөөс дээш бол нислэгийн түвшин, доош бол EGM08 өндрийн тогтолцоонд далайн дундаж түвшин (AMSL)-ээс тооцох);

5.3.7. Агаарын зайг нислэгийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөж эхлэх огноог тодорхойлох.

5.4. Агаарын замд өөрчлөлт орох тохиолдолд:

5.4.1. Агаарын замыг нэрлэх;

5.4.2. Агаарын замд хамаарах холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжийн бүрхэлтийн судалгаа хийх;

5.4.3. Агаарын замын урт, өргөн, дээд болон доод өндрийг тодорхойлох;

5.4.4. Агаарын замын бодит болон соронзон чиглэлийг тодорхойлох;

5.4.5. Агаарын замын аюулгүй нам өндрийн тооцоолол хийх (EGM08 өндрийн тогтолцоонд далайн дундаж түвшин (AMSL)-ээс тооцох);

5.4.6. Агаарын замын ашиглалтыг тодорхойлох (өнгөрөлт, хөөрөлт, буулт);

5.4.7. Агаарын замын статусыг тодорхойлох (Олон улс, орон нутаг, бүс нутгийн);

5.4.8. Агаарын замын төрлийг тодорхойлох (уламжлалт, үзүүлэлтэд тулгуурласан);

5.4.9. Агаарын замын үзүүлэлтийг тодорхойлох (RNAV, RNP гэх мэт);

- 5.4.10. Агаарын замын тодорхой цэгүүдийг тодорхойлох (WGS-84 газар зүйн солбицлын систем ашиглана);
- 5.4.11. Агаарын замын сегмент хоорондын зайг тооцоолох (WGS-84 газар зүйн солбицлын систем ашиглана);
- 5.4.12. Агаарын замын сегмент хоорондын бодит болон соронзон чиглэлийг тооцоолох;
- 5.4.13. Агаарын замын хөдөлгөөний урсгалыг тодорхойлох (нэг чиглэлтэй, эсрэг чиглэлтэй);
- 5.4.14. Бүс нутгийн агаарын замын сүлжилд хамаарах бол хөрш зэргэлдээ улсууд болон ОУИНБ, Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбоо (IATA)-той зөвшилцөх.

5.5. Тодорхой цэгт өөрчлөлт орох тохиолдолд:

- 5.5.1. Тодорхой цэгийг нэрлэх (ОУИНБ-ын iCARD системээр дамжуулан 5 үсгийн код авах);
- 5.5.2. Цэгийн газар зүйн солбицлыг тодорхойлох (WGS-84 газар зүйн солбицлын систем ашиглана);
- 5.5.3. Тодорхой цэгийн зориулалтыг тодорхойлох (заавал илтгэх, хүсэлтээр илтгэх, замын цэг гэх мэт);
- 5.5.4. Тодорхой цэгт хамаарах холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжийн бүрхэлтийн судалгааг хийх;
- 5.5.5. Тодорхой цэгийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхлэх огноог тодорхойлох;
- 5.5.6. Улсын агаарын хил дээр орох, гарах цэг шинээр тогтоох, байрлалыг өөрчлөх, хүчингүй болгох тохиолдолд улсын нисэхийн холбогдох байгууллагатай зөвшилцөх;
- 5.5.7. Улсын агаарын хил дээр орох, гарах цэг шинээр тогтоох, өөрчлөх, хүчингүй болгох тохиолдолд тухайн хиллэж буй улс (ОХУ, БНХАУ)-ын Иргэний нисэхийн удирдах газартай харилцан тохиролцсон албан захидлыг тушаалын төсөлд хавсаргах;
- 5.5.8. Тодорхой цэгийн байрлал солигдсон эсхүл хүчингүй болгосон тохиолдолд ОУИНБ-ын iCARD системээс хасуулах.

Зургаа. Тогтоосон, ангилсан агаарын зайн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх

- 6.1. Энэхүү журмын 3.4-т заасан ажлын хэсэг нь агаарын зайд өөрчлөлт орсноос хойш 3 сарын хугацаанд хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох тайлан, зөвлөмжийг гаргана.
- 6.2. Хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх явцад үйл ажиллагаанд алдаа, дутагдал илэрвэл зохих арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг ажлын хэсгийн нийт бүрэлдэхүүн хариуцна.
- 6.3. Агаарын зайн зохион байгуулалтын хяналт, зохицуулалт хариуцсан иргэний нисэхийн хяналтын байцаагч нь ажлын хэсгийн тайлан, зөвлөмж, холбогдох баримт бичгийн архив үүсгэж, хадгална.

6.4. Агаарын зайн бодлогын хэрэгжилт хариуцсан нэгж нь тогтоосон, ангилсан агаарын зайн байнгын хэрэгцээг хангаж, олон улсын бодлого, чиг хандлагатай нийцүүлэх зорилгоор тогтоосон, ангилсан агаарын зайг 5 жил тутамд хянаж, дүгнэлт хийх ажлыг хариуцан, зохион байгуулна.

Долоо. Журмын хяналт, шинжилгээ

7.1. Энэхүү журмыг холбогдох хууль тогтоомж, Конвенцын хавсралт, баримт бичгүүдэд орсон өөрчлөлтөөс шалтгаалан тухай бүр шинэчилж болно.

7.2. Энэхүү журамд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийн бүртгэлийг Хавсралт 5-д заасны дагуу тогтмол хөтөлнө.

----oOo---

Агаарын замын мэдээллийн загвар

Агаарын замын мэдээлэл				
Нэр				
Статус				
Ашиглалт				
Төрөл				
Ангилал				
Агаарын зайн ангилал				
Урт				
Өргөн				
Дээд өндөр				
Доод өндөр				
Чиглэл				
Агаарын замын бүрдэл				
№	Эхлэх цэг	Төгсгөлийн цэг		
1				
2				
3				
4				
5				
6				
7				
Цэгийн мэдээлэл				
№	Цэгийн нэр	Өргөрөг	Уртраг	Шаардлага
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
Тойм зураг				

Агаарын зайн мэдээллийн загвар

Агаарын зайн мэдээлэл	
Нэр	
Төрөл	
Ашиглалт	
Шаардлага	
Агаарын зайн ангилал	
Хэвтээ хязгаар	
Дээд өндөр	
Доод өндөр	
Огноо	

Агаарын зайг тогтоох, ангилах ажиллагаанд шаардлагатай тооцоот хугацаа

Үе шат	№	Хэрэгжүүлэх ажил	Тооцоот хугацаа (ажлын хоног)
ТӨЛӨВЛӨЛТ	1	Агаарын зайг тогтоох, ангилах саналд үндэслэн агаарын зайг шинэчлэх шаардлагыг тогтоож, удирдлагад танилцуулах	5 хоног
	2	Мэргэжлийн ажлын хэсгийг байгуулах	5 хоног
	3	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй агаарын зай тогтоосон, ангилсан шийдвэртэй танилцаж, шаардлагатай өөрчлөлтүүдийг тодорхойлох	5 хоног
	4	Агаарын зайн зохион байгуулалт, нисэх буудлын ашиглалт, холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжийн хүчин чадал, хамрах хүрээнд дүн шинжилгээ хийх	5 хоног
	5	Өөрчлөлт оруулах шаардлагатай агаарын зайн мэдээлэл болон нислэгийн журам (SID, STAR), сектор зохион байгуулалтад нөлөөлөх эсэхийг тодорхойлох	5 хоног
	6	Агаарын зайн өөрчлөлтийн урьдчилсан төслийг боловсруулах	5 хоног
САНАЛ БОЛОВСРУУЛАХ	7	Аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх	5 хоног
	8	Агаарын зайг дадлагажуур дээр турших	15 хоног
	9	Эрсдэлийн үнэлгээ, НХУ-ын туршилтын үр дүнг харгалзан урьдчилсан төсөлд холбогдох өөрчлөлтийг оруулах	5 хоног
	10	Агаарын зайн өөрчлөлтийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхлэх огноог AIRAC тогтолцооны тооцоот хугацаатай уялдуулан тодорхойлох	3 хоног
	11	Агаарын зайн өөрчлөлтийн талаар агаарын зайн оролцогч талуудыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд хэлэлцүүлгийн үр дүнг төсөлд нийцүүлэх	3 хоног
	12	ОУИНБ-ын iCARD системээр дамжуулан тодорхой цэгийн 5 үсгийн код авах	30 хоног
	13	Нислэгийн хөдөлгөөний удирдлага хариуцсан нэгжээс шинээр тогтоож буй тодорхой цэгийн нэрний талаар санал авах	5 хоног
	14	Нислэгийн хөдөлгөөний удирдлага хариуцсан нэгжээс ирүүлсэн саналаас шалтгаалан шаардлагатай тохиолдолд ОУИНБ-аас тодорхой цэгийн 5 үсгийн кодыг өөрчлөн авах	14 хоног
	15	Агаарын зайн өөрчлөлтийг батлах тухай Зам, тээврийн сайдын тушаалын төсөл боловсруулах	14 хоног
	16	Зам, тээврийн сайдын тушаалын төслийг ИНЕГ-ын цахим хуудаст 30-аас доошгүй хоног байршуулан олон нийтээс нээлттэй санал авах	30 хоног
БАТАЛГААЖУУЛАХ	17	Нөлөөллийн шинжилгээ хийх, нөлөөллийн шинжилгээний танилцуулга бэлтгэх	1 хоног
	18	Ажлын хэсгийн тайлан бэлтгэх	5 хоног
	19	Ажлын хэсгийн тайланг ИНЕГ-ын даргад танилцуулан, шийдвэр гаргуулах	5 хоног
	20	Зам, тээврийн сайдын тушаалын төслийг хавсралтын хамт иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх	3 хоног

ХЭРЭГЖҮҮЛЭХ	21	Агаарын зайг ашиглахтай холбогдсон сургалтуудыг зохион байгуулах	30 хоног
	22	Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-ээр олон улсад зарлан мэдээлэх	90 хоног
	23	Нисэхийн системүүдийн мэдээллийн санд өөрчлөлт оруулах	5 хоног
	24	Үйл ажиллагаанд ашиглаж эхлэх	1 хоног
ХЭРЭГЖИЛТЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ	25	Агаарын зайд өөрчлөлт орсоноос хойш 3 сарын хугацаанд хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх	90 хоног
	26	Холбогдох тайлан, зөвлөмжийг гаргах	5 хоног
	27	Үйл ажиллагаанд алдаа, дутагдал илэрвэл зохих арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх	-
Нийт (Хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх +95 хоног)			294 хоног



Агаарын зайг тогтоох, ангилах саналын маягт

Маягтын зорилго

- Иргэний нисэхийн зориулалтаар ашиглах Монгол Улсын агаарын зайд өөрчлөлт оруулах хүсэлтийг агаарын зайн хэрэглэгчдээс хүлээж авах

Маягттай холбоотой мэдээлэл

- Хүсэлт гаргагч нь тухайн өөрчлөлттэй холбоотой аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ болон нөлөөлийн шинжилгээг хавсаргана.
- Маягтыг anaar@mcaa.gov.mn хаягаар илгээнэ.
- Хүсэлтийг албан бичгээр ирүүлэх тохиолдолд энэхүү маягтыг бөглөж, хавсаргана.
- Хүсэлтийг хүлээн авсан тухай лавлах тохиолдолд +976-71282229 дугаараар холбогдоно.

Маягт бөглөх заавар

- Агаарын зайг шинээр тогтоох эсхүл тогтоогдсон агаарын зайн ангилал, зориулалт, бүтэц, хил хязгаарыг өөрчлөх, хүчингүй болгох хүсэлт гаргах тохиолдолд ➔ 3;
- Агаарын зам шинээр тогтоох эсхүл тогтоогдсон агаарын замд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хүсэлт гаргах тохиолдолд ➔ 4;
- Орох, гарах цэг, илтгэх цэг шинээр тогтоох эсхүл тогтоогдсон цэгийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хүсэлт гаргах тохиолдолд ➔ 5-ыг тус тус бөглөнө.

Хүсэлт шийдвэрлэх үйл явц

- Хүсэлтийг холбогдох хууль тогтоомж, стандарт шаардлагын хүрээнд хэрэгжүүлэх боломжтой эсэхийг ИНЕГ-ын Агаарын зайн бодлого хариуцсан нэгж хүлээн авч судлан, холбогдох хариуг албан журмаар хүргүүлнэ.
- Шаардлагатай тохиолдолдолд нэмэлт мэдээлэл авахаар хүсэлт гаргагчтай холбогдох тул мэдээллийг үнэн зөв бөглөх шаардлагатай.

Энэхүү маягтад тусгасан хувь хүний мэдээллийг зөвхөн тухайн хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор ашиглана.

1. Хүсэлт гаргагч

Хүсэлт гаргагч байгууллагын мэдээлэл

Байгууллагын нэр /Хувь хүн ➡ 2 руу шилжинэ үү/

Ажлын утас

Байгууллагын и-мэйл

Факс

Хаягийн мэдээлэл

Тоот

Гудамж

Хороо

Дүүрэг

Хот/Аймаг

Улс

Зип код

2. Холбоо барих хүн

/Холбоо барих хүний мэдээллийг оруулна уу/

Овог, нэр

Гар утас


И-мэйл

Хүсэлтийн төрлийг сонгоно уу


- ☐ Агаарын зай шинээр тогтоох
- ☐ Агаарын зам шинээр тогтоох
- ☐ Тодорхой цэг шинээр тогтоох
- ☐ Агаарын зайд өөрчлөлт оруулах
- ☐ Агаарын замд өөрчлөлт оруулах
- ☐ Тодорхой цэгт өөрчлөлт оруулах
- ☐ Агаарын зай хүчингүй болгох
- ☐ Агаарын зам хүчингүй болгох
- ☐ Тодорхой цэг хүчингүй болгох

3. Агаарын зайтай холбоотой өөрчлөлт


Агаарын зайд оруулах өөрчлөлтийн дэлгэрэнгүй мэдээлэл (зорилго, шийдвэрлэж буй асуудал зэрэг)




Байршил (Солбицол)



Босоо хязгаар (дээд болон доод өндөр)



Хэвтээ хязгаар (уртраг, өргөрөг)




Өөрчлөлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөөт хугацаа (өдөр/сар/он)


	/		/	
--	---	--	---	--

4. Агаарын замтай холбоотой өөрчлөлт


Агаарын замд оруулах өөрчлөлтийн дэлгэрэнгүй мэдээлэл (зорилго, шийдвэрлэж буй асуудал зэрэг)



Агаарын замын нэр, дугаар (хүчинтэй агаарын замд өөрчлөлт оруулах тохиолдолд)



Агаарын замын чиглэл (шинээр агаарын зам тогтоох тохиолдолд)



Өөрчлөлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөөт хугацаа (өдөр/сар/он)



5. Орох, гарах цэг, илтгэх цэгтэй холбоотой өөрчлөлт

Цэгтэй холбоотой оруулах өөрчлөлтийн дэлгэрэнгүй мэдээлэл (зорилго, шийдвэрлэж буй асуудал зэрэг)

Цэгийн нэр, байршил (Хүчинтэй цэгийг өөрчлөх тохиолдолд)

Цэгийн байршил (шинээр цэг тогтоох тохиолдолд)

Хиллэж буй улсуудтай зөвшилцсөн эсэх (Орох, гарах цэг шинээр тогтоох тохиолдолд)

Өөрчлөлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөөт хугацаа (өдөр/сар/он)

/ /

Хүсэлт гаргасан

Овог нэр

Албан тушаал

Гарын үсэг

Огноо (өдөр/сар/он)

 / /

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлт		
№	Огноо	Өөрчлөлтийн тэмдэглэл
1		ИНЕГ-ын Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийн газраас шинээр боловсруулав.